



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/373


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а, 29.1.4 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 3/03 дугаар төсөв батлах тухай тогтоолын 4.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн сайн дурын “Ногоон хивс” аяныг Жаргалант сумын нутаг дэвсгэрт зохион байгуулсугай.
2. Бүх нийтийн сайн дурын “Ногоон хивс” аяныг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, аяны үйл ажиллагааны зардлыг 2256000 /хоёр сая хоёр зуун тавин зургаан мянган/ төгрөгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дээрх төсөл арга хэмжээний зардлыг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.18-д тусгагдсан “Ногоон хөгжлийн хөтөлбөр”-ээс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.
4. Аяныг иргэд олон нийт, аж ахуй нэгж байгууллагын идэвх оролцоог өрнүүлэн үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг Ховд аймгийн Залуучуудын холбооны тэргүүн /Ш.Батжаргал/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/373-Bo
112 2020

Аймгийн Засаг даргын 2021 оны
07 дугаар сарын 29-ний өдрийн
А/373 дугаар захирамжийн хавсралт



**БҮХ НИЙТИЙН САЙН ДУРЫН “НОГООН ХИВС” АЯНЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ЗОРИУЛАН ГАРАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ**

№	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /төг/	Тоо ширхэг	Мөнгөн дүн /төг/	Хариуцах эзэн
1	Видео хийх	-	-	-	-	Ховд аймгийн Залуучуудын холбоо, ХАЗХЗ
2	Авто машингүй бүс, Эко бүс	-	-	-	-	Чиг үүргийн байгууллага
3	Сайн дурын ажилд оролцсон хүмүүст талархлын бичиг, бусад зүйлс олгох (талархлын бичиг, зураг, маск-5 ш)	ширхэг	2700	580	156600 0	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар
4	Ваннер хэвлүүлэх	ширхэг	250000	1	250000	ЗДТГ, ИТХ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар
5	Машинаар элс буулгах	-	-	-	-	Чиг үүргийн байгууллага
6	Цемент	уут	17500	8	140000	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
7	Уут, бээлий ... гм	ширхэг	500	600	300000	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
Нийт						2 256 000

-oOo-